

АХМАД ХИЛЧДИЙН ОЙН ДУРСАМЖ

Уншигч түмэн олондоо энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатраар овоглосон цэргийн гавьяаны одонт төрөлх ангийн маань түүх 90 жилийн ойн арга хэмжээ ахмад үеэ хүндэтгэн хилчин ахмадуудын сэтгэлийн хөг эгшгийг сэргээсэн өргөн дэлгэр сайхан болж өндөрлөлөө.

Ахмадууд бид 90 жилийн ой хүрээнд дурсамж 2022 уулзалтыг зохион байгуулахын зэрэгцээ ангийн түүхийн номыг бүтээх санхүүжилт, ангийн хүн эмнэлгийн албыг төрийн соёрхолт гавьяат эмч Төмөрбаатарын нэрэмжит, ангийн алдрын танхимыг тохижуулахад санхүүжилтийг босгох зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэв.

Дээрх ажлуудад санаачилгатай ажиллаж 5.0 сая төгрөгийн хандив өгсөн ахлах ахлагч Г.Дашцэрэнгийн гэр бүл, Юмхүү тэдний үр хүүхдүүд, гавьяат эмч Төмөрбаатар болон сэтгэлийн хандив өгсөн үе үеийн ахмад хилчдэдээ гүн талархал дахин дэвшүүлье.

Ойн арга хэмжээний үеэр явагдсан спортын мастер Г.Нарангэрэлийн нэрэмжит “Волейбол”, ахмад хилчин агсан Д.Ретовын нэрэмжит ширээний теннисний тэмцээн зэрэг спортын наадмууд ахмад хилчдийн маань дурсгалтай мөчүүдийн нэг байлаа.

Ой тэмдэглэх үеийн бэлтгэл ажил болон бүхий л арга хэмжээг хүн бүрийн сэтгэл таашаалд хүргэх юмсан гэсэн ангийн захирагч, хурандаа Э.Майдар болон нийт бие бүрэлдэхүүндээ нийт ахмад

хилчдийнхээ өмнөөс баярлалаа гэдгээ дахин хэлье.

Ангийн түүхт 90 жилийн ой ахмад хилчид бидэнд 100 жилээ үзэх, одооноос бэлтгэх их эрч хүчийг үлдээснийг энэ дашрамд дурдахын зэрэгцээ түүхийг бид бас бүтээлцэж, түүхээр сэтгэлийн амар амгаланг цэнгэн эдэлж жаргадаг юм байна гэдгийг хүн бүр мэдэрсэн дурсамж дүүрэн баяр боллоо.

Ингээд төрөлх ангийнхаа үе үеийн ахмад хилчид, азай буурлууд одоо ажиллаж байгаа бие бүрэлдэхүүндээ амьдралын гэгээлэг сайхан бүхийг хүсье.

Ахмад хилчид, бэлтгэл дэд

хурандаа Д.Ганбаатар

*Төрөлх анги байгуулагдсаны
баярын сэтгэгдэл*

2023 оны 09 дүгээр сарын 09

Говь нутгийн налгар шар нар ээсэн тунгалаг сайхан өдөр

Хил хамгаалах байгууллагыг нэгэн их далай гэвэл тус анги цэнгэг уст нуур мэт. Уул, толгод, булаг, шанд бүр нь түүх хэлхэх хийморь золбоот хилчдийн өлгий нутаг Алтайн цэнхэр хязгаарт түүхэн баяраа тэмдэглэхээр олон өнгийн цэцэг шиг одон медалиа гялалзуулсан ахмад хилчид минь нуурандаа чуулж буй шувууд шиг шуугьж байгаа нь хүмүүний амьдралын аз жаргалтай цаг мөчүүдийн нэгээхэн хэсэг нь энэ байх даа гэсэн бодолд хүргэж байлаа.

Миний бие хил хамгаалах байгууллагынхаа 50 насан дээр алтан босгыг нь алхаж орсноос хойш 40 гаруй жил өнгөрчээ. Зочид төлөөлөгчдийг харахад миний алба хаасан 30 гаруй жилийн хугацаанд мөр зэрэгцэн ажиллаж байсан нөхөд буюу нэгэн ёсны намайг сургууль төгсөөд очиход тосож авч, өсгөж, хүмүүжүүлж, амьдралын их харгуйд

зааж зөвлөж байсан дарга, ах, эгч, андууд минь байлаа. Ойн баярын үйл ажиллагааны хөтөлбөр маш сайн төлөвлөгдсөн сайхан болж, өндөрлөсөн.

Ойг тэмдэглэх үйл ажиллагаа нь бүтээн босгох их ажлыг бий болгодгоороо онцлогтой, үлдэцтэй байдаг байна. Хилчин баатруудын цогц хөшөө, жагсаалын талбай гээд олон сайхан бүтээлийг хийцгээлээ. Ойн хоёр өдөрт манайх гэдэг айл хөлтэйхөн өнгөрөөсөн нь сар шинийн баяр болж байгаа ч юм шиг санагдаж байлаа. Нөхөд маань ангиа гоё, сайхан болсныг ам уралдан ярьцгаасны хамгийн их сэтгэл хөдлөгдсөн агшин нь хойд замын угтах хаалга дээр монгол дээлтэй бүсгүй идээний дээжээ өргөн угтан авсан нь сайхан байлаа гэж хэд хэдэн эмэгтэй нулимс цийлгэнүүлэн ярьж байв. Хамгийн энгийн юм аугаа байдгийн учир биз ээ. Сэтгэл хөдөлж баярын магнай тэнийхийн зэрэгцээ гуниг төрж байсан нь насны намартаа налайж явах олон анд нөхөд минь нарт хорвоогоос эрт буцсаных байлаа (С.Дашбалдан, Б.Содномдаржаа, Ц.Лодойдамба, Г.Сономдаржаа, Ц.Нармандах, Р.Батням, С.Мөнхөө) Отрядын үндсэн бүрэлдэхүүний орон сууцны хашааг 30 хол давсан хэмийн халуунд манай албан хаагчид залуу насны эрч хүчийг үзүүлэн шинэчлэн барилаа. Тус ангийн бичээчээр ажиллаж байсан Г.Нарангэрэл “Волейбол-ын спортын мастер” цол гардаж авсан нь юм нүдээ олно гэдэг боллоо.

Манай малын Батсүх ах 80 дөхсөн насандаа машин барьчихсан хөгшнөө суулгачихсан олон зуун км газрыг туулж яваа нь бахадмаар.

Хурандаа Ц.Ганболд маань хилчдийнхээ оюуны мэлмийг

нээхийн төлөө, эрдэм судлалын их ажилд нас бие үйл хайрлан бодит ажлуудыг хийж зүтгэж явааг бодохуйд сэтгэл татмаар. Ж.Шатарбал маань залуугийнх шигээ хангайн хүрэн буга шиг гялалзаж явна лээ. Г.Сономдаржаа ахын эхнэр Ч.Өлзийхишиг эгч хүү, охин хоёроо дагуулчихсан төрж өссөн нутгийг нь үзүүлж, аавынх нь алба хааж амьдарч байсан анги, орон бууриа эргэж яваа нь он цагийн дурсамж өгүүлсэн түүхэн хүүрнэл болж сэтгэлд үлдсэн юм.

Тахийн шар нуруу, Хэнгэрэгтэйн хөндий, Хагийн хоолой, Чандмань- Богд, Аргал шанд, Өнчин толгой, Тулга толгой, Балгант, Уушиг, Хөндийн хар, Цагаан булаг, Царигийн ус зэрэг манай ахмад хилчдийн галтай дөлтэй залуу насных нь им тамга болсон эдгээр нэршил яруу найргийн шад мөр мэт сэтгэлд нь буудаг биздээ. Энэ л хүмүүстэй олон жилийн дараа уулзаж золгон гэдэг их ойн далбаан доорх миний баяр байлаа. Энэ дашрамд их ойн баяраа нүүр бардам, сэтгэл дүүрэн, ханагар тэмдэглэсэн ангийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд баярлалаа.

Ингээд хилийн замаар хилчний дуугаа өргөж явсан, яваа эрхэм дайчин анд нөхөддөө та бүгдийн маань бие цэгц, лагшин тунгалаг, амьдрал хангалуун, ухаан төгөлдөр байхын ерөөлийг өргөн барья.

*Ахмад хилчин, бэлтгэл дэд хурандаа
С.Зэсэндүйчир*